




## ИНФОГРАФИК /2 ДУГААР САР/

### 1.ИНФЛЯЦИ

Жилийн инфляци 2016 оны 02 дугаар сард улсын хэмжээнд 2 хувь, Улаанбаатар хотод 1,6 хувьтай байна.


Суурь инфляци 02 дугаар сарын байдлаар жилийн 3,5 хувь байна.




### 2.МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Мөнгөний нийлүүлэлт 2016 оны 02 дугаар сарын эцэст өмнөх сарынхаас 164,2 тэрбум төгрөгөөр буюу 1,7%-иар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 215,5 тэрбум төгрөгөөр буюу 2.1%-иар буурч 10 015,0 тэрбум төгрөг байна.

Мөнгөний нийлүүлэлт /тэрбум төг/




Мөнгөний нийлүүлэлт /жилийн өсөлт/



### 3.ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН АЛБАН НӨӨЦ


Гадаад валютын улсын албан нөөц /тэрбум ам.доллар/



2016 оны 01 дүгээр сарын байдлаар гадаад валютын албан нөөц 1,32 тэрбум ам.доллар болж өмнөх сараас 0,03%-иар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 0,32%-иар буурчээ.




#### 4. ХАДГАЛАМЖ

Нийт хадгаламж 02 дугаар сарын байдлаар 7437,4 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 1,03%-иар буурчээ. Үүнээс төгрөгийн хадгаламж 5370,4 тэрбум төгрөгт хүрч өмнөх сараас 1,8%-иар буюу 57,9 тэрбум төгрөгөөр өссөн, өмнөх оны мөн үеийнхээс 3,9 тэрбум төгрөг буюу 0,07%-иар өссөн үзүүлэлттэй байна.




#### 5. ЗЭЭЛ

2016 оны 02 дугаар сарын эцэст нийт зээлийн өрийн үлдэгдэл 11628 тэрбум төгрөгт хүрч өмнөх сарынхаас 155 тэрбум төгрөгөөр буюу 1,3хувиар буурсан ба өмнөх оны мөн үеийнхээс 548,72 тэрбум төгрөгөөр буюу 4,5 хувиар буурсан байна.



Нийт зээлийн 7,83 хувийг чанаргүй зээл эзэлж байна.



## 6. ГҮЙЛГЭЭНД ГАРГАСАН БЭЛЭН МӨНГӨ



2016 оны 02 дугаар сарын эцэст гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 655,5 тэрбум төгрөг болж өмнөх сараас 58,3 тэрбум төгрөгөөр буюу 8,1%-иар буурч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 120,4 тэрбум төгрөгөөр буюу 15,5 %-иар буурчээ.

## 7. ГАДААД ДОТООД ЦЭВЭР АКТИВ

Гадаад цэвэр актив өмнөх сараас 99,5 тэрбум төгрөгөөр буюу 2,3 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 1842,7 тэрбум төгрөгөөр буюу 74,5 хувиар буурч -4315,9 тэрбум төгрөг болов.



## 8. ХУДАЛДАН АВСАН АЛТНЫ ХЭМЖЭЭ, КГ



2015/2 сар	218,4 кг
2015/3 сар	287,0 кг
2015/4 сар	536,7 кг
2015/5 сар	895,4 кг
2015/6 сар	1344,1 кг
2015/7 сар	1647,6 кг
2015/8 сар	1993,8 кг
2015/9 сар	2793,5 кг
2015/10 сар	2674,0 кг
2015/11 сар	1518,4 кг
2015/12 сар	694,8 кг
2016/01 сар	644,1 кг
2016/02 сар	538,5 кг